



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/215

Мандалговь

Комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын Нарлаг гудамж дагуух зам, түүний дагуух тохижилтын ажлын зураг, нэгдсэн төсвийн ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Лхагвасүрэн (Засаг даргын тамгын газрын дарга),

Нарийн бичгийн дарга: Н.Саранзаяа (Сангийн ня-бо)

Гишүүд: Э.Цэрэннадмид (Дотоод ажилтан)

Л.Батсугир (Хэвлэл мэдээллийн ажилтан)

2. Гэрээнд заагдсаны дагуу зураг төсвийн ажлын шаардлага хангаж байгаа эсэхийг нягтлан шалгаж, баримтжуулж хүлээж авахыг комиссын дарга, гишүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ